



ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 19/08

Улаанбаатар хот

Автотээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулах бодисыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай

Автотээврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 51 дүгээр захирамжаар батлагдсан "Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажиллах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор автотээврийн хэрэгслээс ялгарч буй хорт бодисын хэмжээг бууруулах ажлын хүрээнд дараах арга хэмжээ авч, хэрэгжүүлж ажиллахыг холбогдох газруудад даалгасугай:

1.1. Нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслийн парк шинэчлэлийг 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үе шаттайгаар байгалийн хий, цахилгаан эх үүсвэрээр ажилладаг, мөн евро-5 стандартын шаардлага хангасан хөдөлгүүр бүхий автобусаар шинэчлэх, ашиглагдаж буй автобусанд шүүлтүүр суурилуулан үйлчилгээнд оролцуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарт тус тус даалгасугай.

1.2. Нийслэл орчмын шалган бүртгэх товчоогоор дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс гарч буй утаанд хэмжилт хийж, зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан агаар бохирдуулагч бодис ялгаруулж буй тээврийн хэрэгслийг Улаанбаатар хот руу нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Тээврийн цагдаагийн албаны дарга Д.Амарсайхан нарт тус тус даалгасугай;

1.3. Зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү бохирдуулах бодис ялгаруулж байгаа болон утааны шүүлтүүргүй дизель хөдөлгүүртэй автобус, ачааны автомашиныг 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Нийслэлийн замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх хяналтыг тогтмол хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Зам тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар, Тээврийн цагдаагийн албаны дарга Д.Амарсайхан, нарт тус тус даалгасугай;

1.4. Тээврийн хэрэгслээс ялгарч буй бохирдуулах бодисыг бууруулах талаар нэмэлт тоног төхөөрөмж болон бусад төрлийн бүтээгдэхүүнийг турших, утааны хор уршиг, сөрөг үр дагаврын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, иргэдээс санал, мэдээллийг тогтмол хүлээн авах талаар арга хэмжээ зохион байгуулж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарт тус тус даалгасугай;

1.5. Ашиглалтаас хасагдсан автомашин, түүний эд ангийг устгах, дахин боловсруулах үйлдвэр байгуулахыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарт тус тус даалгасугай;

1.6. Евро-5 стандартад нийцсэн, чанарын шаардлага хангасан шатахуун, байгалийн хийгээр хангах ажлыг тогтвортой зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Д.Загджавд даалгасугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Ч.Гантулгад даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА Н.ЦЭРЭНБАТ

